lendmn

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо,
Жуулчны гудамж-34, "Сувд Төв" Оффис
Утас: +976 - 77070101
И-мэйл: contact@lend.mn

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ-Д

2020 оны 3 сарын 23 өдөр № 03/75 Улаанбаатар хот

***Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах тухай***

Дэлхийн 100 гаруй улс оронд дэгдээд буй шинэ коронавирус (COVID-19) халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 сарын 19-ний өдрийн 64 тоот тогтоолоор 2020 оны 3 сарын 30-ны өдрийг хүртэл олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглоод байна.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол болон Улсын онцгой комиссын холбогдох шийдвэрийн дагуу "ЛэндМН ББСБ" ХК ("Компани") нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс 2020 оны 3 сарын 28-ны өдөр хуралдуулахаар товлоод байсан Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ("Хурал")-ыг хугацаагүйгээр хойшлуулж, энэ тухай Санхүүгийн Зохицуулах Хороо ("СЗХ")-д 2020 оны 2 сарын 21-ний өдөр мэдэгдээд байсан билээ.

Шинэ коронавирус (COVID-19) халдварт өвчний дэгдэлт хэзээ намжих нь тодорхоогүй, түүнчлэн манай улсад уг халдварт өвчний тохиолдол албан ёсоор бүртгэгдээд байгаа энэхүү эгзэгтэй цаг үед Компанийн зүгээс Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2020 оны 3 сарын 05-ны өдөр нийт хувьцаат компаниудад хандан гаргасан уриалгыг хүлээн авч, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 3 сарын 09-ний өдрийн 20/11 тоот тогтоолоор Хурлыг урьд товлосон хугацаанд буюу 2020 оны 03 сарын 28-ны өдөр "Цахим хэлбэр"-ээр зохион байгуулахаар шийдвэрлээд байна.

Ийнхүү Хурлыг "Цахим хэлбэр"-ээр зохион байгуулах гэж буй нь Компанийн төдийгүй Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн болон хувьцаат компаниудын түүхэнд анхдагч үйл явдал болж байгаа тул Компанийн зүгээс цаашид жишиг болохуйц шийдэл хэрэгжүүлж, Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах ажиллахаар хүчээ дайчилж байна.

Хавсралтаар:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 3 сарын 09-ний өдрийн 20/11 тоот тогтоол

Хүндэтгэсэн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ О.БОЛДБААТАР

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

lendmn

# "ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

**Компанийн нэр:** "ЛэндМН ББСБ" ХК

**Хаяг:** Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж, Сувд төв, 201 тоот

**Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдөр, цаг:** 2020 оны 3 сарын 28-ны өдөр 12:00 цаг

**Хурал хуралдах хэлбэр:** Компанийн фэйсбүүк хуудсаар дамжуулан **цахим хэлбэрээр**

**Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:**

2020 оны 2 сарын 25-ны өдөр

**Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал:**

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай;
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсвийг батлах;
5. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэн батлах эсэх асуудал;
6. Компанийн өөрийн хөрөнгийг хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх эсэх асуудлыг хэлэлцэн батлах.

**Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:**

Хувьцаа эзэмшигчид **2020 оны 3 дугаар сарын 25-ны** өдрийг хүртэл өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хандан, эсхүл Компанийн цахим хуудсаар дамжуулан хурлын баримт бичигтэй танилцаж болно.

Хурал зохион байгуулах комисс нь **Даваа-Баасан гаригт 09:00-16:00** цагийн хооронд ажиллана.

**Хурал зохион байгуулах комиссын мэдээлэл:**

- "ЛэндМН ББСБ" ХК-ийн Санхүү, үйл ажиллагаа хариуцсан захирал М.Түвшинжаргал, **tuvshinjargal@lend.mn**
- Харилцагчийн үйлчилгээний төвийн менежер О.Батзаяа, **batzaya@lend.mn**
- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Мөнхцэцэг, **board@lend.mn**

**Нэмэлт мэдээлэл:**

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын болон хуралд цахим хэлбэрээр хэрхэн оролцож, санал өгөх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн цахим хуудас **www.lend.mn**, фэйсбүүк хуудас **https://www.facebook.-com/LendMN/**-д хандах, эсхүл Харилцагчийн үйлчилгээний төвийн **77070101** дугаарт хандан авах боломжтой.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

## "ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 3 сарын 09-ний өдөр | № 20/11 | Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
цахим хэлбэрээр хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 65 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3, 76.1.18 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 сарын 19-ний өдрийн 64 тоот тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 сарын 05-ны өдөр нийт хувьцаат компаниудад хандан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгсэл, цахим технологийг ашиглан хуралдуулах тухай мэдэгдэл (http://www.frc.mn/a/3156) болон Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 3 дугаар бүлэг, "ЛэндМН ББСБ" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 20/09 тоот тогтоол, 2020 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн энгийн санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "ЛэндМН ББСБ" ХК (цаашид "Компани")-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс 2020 оны 03 сарын 28-ны өдрийн 12:00 цагт хуралдуулахаар товлосон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Хувьцаа эзэмшигчдийг нэг дор бөөнөөр цуглуулахгүй байхаар буюу цахим хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэсүгэй.

2. Энэхүү тогтоолын 1-т заасантай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж, зохион байгуулалтын холбогдох хууль, тогтоомжийг мөрдүүлэн ажиллахыг Хурал зохион байгуулах комисс (Комиссын дарга М.Түвшинжаргал), Компанийн Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

ТУЗ-ийн ДАРГА:

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ